



Bank of Mongolia

# ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Г.Даваахүү

[davaakhuu@mongolbank.mn](mailto:davaakhuu@mongolbank.mn) Утас: 310215



## Агуулга

<b>ФАТФ-ын 40 Зөвлөмж тухай ерөнхий ойлголт</b>	<b>3</b>
Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх	6
Зөвлөмж 11-15	12
Зөвлөмж 16 Данс хоорондын гүйлгээ	17

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠬᠡᠭᠢᠯᠢ ᠪᠠᠨᠭ



## ФАТФ-ын 40 Зөвлөмжийн тухай ерөнхий ойлголт

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг улс, орон бүрт нэг түвшинд хүргэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд улс хоорондын хамтын ажиллагаанд учирч болох хүндрэлүүдийг даван туулах зорилгоор Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагаас гаргасан стандарт юм. Хэдийгээр албан ёсны нэршил нь “Зөвлөмж” боловч эдгээр зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад Мөнгө угаахтай тэмцэх бүсийн байгууллагуудын зүгээс үнэлгээ хийж хангалтгүй үнэлгээ авсан улс, орныг Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагын зүгээс “Саарал”, “Хар” жагсаалтад оруулан бусад улс орнуудыг жагсаалтад орсон улстай санхүүгийн харилцаанд орохдоо өндөр сонор, сэрэмжтэй байж, учирч болох эрсдэлээс өөрсдийгөө хамгаалахыг уриалдаг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь “Зөвлөмж”-д бүрэн дүүрэн нийцээгүй байх нь санхүү, эдийн засгийн гадаад харилцаанд ихээхэн сөрөг үр дагвартай болно. Иймд “FATF-ийн 40 Зөвлөмж”-ийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавигдах олон улсын стандарт гэж үздэг байна.

Зөвлөмж



## ФАТФ-ын 40 Зөвлөмжийн тухай ерөнхий ойлголт

- ❑ 2012 оны 2 дугаар сард “FATF-ийн 40 Зөвлөмж”-д агуулга, хэлбэрийн нэлээд өөрчлөлтүүд орсон байна. Нэмэлт өөрчлөлтүүдийг нэгтгэн дүгнэвэл:
  1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс гадна цөмийн зэвсгийг дэлгэрүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаатай мөн тэмцэхээр зөвлөмжийг агуулгын хувьд өргөжүүлсэн байна.
  2. Ноцтой үр дагвар бүхий татварын гэмт хэргийг мөнгө угаахын суурь гэмт хэрэгт хамруулахаар тусгасан байна.
  3. Эцсийн үр шимийг хүртэгч /Beneficial owner/-ийг тодорхойлох үйл ажиллагааг илүү тодорхой, хэрэгжүүлж болох түвшинд тодорхойлсон байна.
  4. Улс хоорондын хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцааг илүү боловсронгуй болгохоор нэмэлт орсон байна.

МОНГОЛ  
УЛСЫН  
ХӨГЖЛИЙН  
БАНК



## ФАТФ-ын 40 Зөвлөмжийн тухай ерөнхий ойлголт

5. Эрсдэлийн үнэлгээ, эрсдэлд суурилсан хэрэгжилтийг оруулж ирсэн.
6. Өмнөх зөвлөмжид тавигдаж буй шаардлагуудыг томъёолохдоо зөвлөсөн хэлбэрийг үг, хэллэг /should/ хэрэглэж байсан бол энэ удаад заавал хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэсэн үг, хэллэг /must, shall/ хэрэглэсэн нь өөр сонголт байхгүйг илтгэж байна.
7. Өмнөх зөвлөмж 40+9 гэж байсан. 40 Зөвлөмж нь мөнгө угаахтай тэмцэх, 9 зөвлөмж буюу тусгай 9 зөвлөмж нь терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд чиглэсэн байсан бол энэ удаад тусгай 9 зөвлөмжийг 40 зөвлөмжийн холбогдох хэсгүүдэд нэгтгэн нийт 40 зөвлөмж болгосон байна. Үүнтэй уялдуулан бүлэг болгон хуваасан байдалд өөрчлөлт орж зөвлөмжүүдийн харилцан уялдаа холбоо, логик дэс дарааллыг харгалзан нийт 7 бүлэгт хуваасан нь илүү ойлгомжтой болсон. “Нэмэлт тайлбар” хэсэг илүү дэлгэрэнгүй, тодорхой болсон байна.

Зөвлөмж



## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

□ Харилцагчийг таньж мэдэх:

Хэзээ хийх бэ?

1. Санхүүгийн харилцаа эхлэн тогтоох үед,
  2. дансгүй эсхүл тогтвортой санхүүгийн харилцаа үүсгээгүй этгээдийн тохиолдлын чанартайгаар хийж байгаа гүйлгээ нь **15,000 USD/EUR**-гоос их бол, зарим төрлийн цахим шилжүүлэг\*
  3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой байх сэжиг бүхий тохиолдолд,
  4. Харилцагчийн талаар өмнө байгаа мэдээллийн үнэн зөв, бодиттой байдалд эргэлзээ төрсөн бол харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулахыг санхүүгийн байгууллагуудад **хууль, эсвэл заавал биелүүлэх шаардлагатай бусад эрх зүйн баримт бичигт үүрэг хэлбэрээр тусгах.**
- Нэргүй эсхүл илт хуурамч нэрээр данс хөтлөхийг хориглоно.

Харилцагчийг таньж мэдэх



## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

### □ ХТМ үйл ажиллагааны хүрээнд юу хийх вэ?

1. Харилцагчийн хэн болохыг тогтоох, найдвартай бичиг баримт, мэдээллийн эх үүсвэрээс нягтлах,
2. Эцсийн өмчлөгч нь хэн болохыг тодорхойлох бололцоотой бүх арга хэмжээг авах, хуулийн этгээд, гэрээ хэлцэлийн хувьд өмчлөгч болон хяналтыг гартаа авч байгаа этгээдийг тодорхойлох,
3. Бизнесийн харилцаа үүсгэх зорилго, цаашид энэ харилцаа хэрхэн үргэлжлэх талаар мэдээлэлтэй болох,
4. Харилцагчийн хийж буй гүйлгээ нь:
  - уг харилцагчийн талаарх санхүүгийн байгууллагын ойлголт, мэдээлэлтэй нийцэж байгаа эсэх,
  - Эрхэлж буй бизнестэй тохирч байгаа эсэх,
  - Эрсдэлийн үнэлгээтэй нийцэж буй эсэхэд байнга хяналт тавьж, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлнэ.

ᠬᠡᠳᠡᠮᠡᠵᠢ 10, ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭᠴᠢᠭᠢᠭᠢᠨ ᠲᠠᠨᠢᠵᠢᠨ ᠮᠡᠳᠡᠬᠡ



## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

- Харилцагч нь хуулийн этгээд байх тохиолдолд авах арга хэмжээ:
  1. Харилцагчийн бизнесийн үйл ажиллагаа, өмчлөгч, хяналтын талаар ойлголттой байх үүрэгтэй. Удирдлагын нэр.
  2. Хуулийн этгээдийн оноосон нэр, хуулийн этгээдийн төрөл, бодитоор оршдог болохыг нотлох баримт, бүртгэлийн болон үйл ажиллагаа явуулдаг хаяг.
  3. Хаанахын ямар байгууллагын хяналт, зохицуулалтад хамрагддаг.

Хуулийн этгээдийн өмчлөгчийг тогтооход баримтлах дараалал:

1. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч хүнийг тогтоох/ хэдээс дээш/
2. Дээрх боломжгүй бол хуулийн этгээдэд хяналт тогтоож байгаа этгээдийг олох
3. Дээрх 2-уулаа боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг тогтоох боломжтой бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠭᠤᠨ  
ᠪᠠᠨᠠᠭ





## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

### □ Харилцагчийн мэдээллийг нягтлах хугацаа:

- Дансгүй харилцагчийн хувьд Харилцагчийн болон өмчлөгчийн талаарх мэдээллийг гүйлгээг хийх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэх явцад нягтлана.

Санхүүгийн харилцаа тогтоосны дараа харилцагчийн мэдээллийг нягтлах нь зөвшөөрөгдсөн бол:

1. Санхүүгийн үйлчилгээ үзүүлсний дараа мэдээллийг нягтлах нь хэрэгжүүлэх боломжтой,
2. Бизнесийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахааргүй
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс хамгаалах үр дүнтэй арга хэмжээ авахад саадгүй байх шаардлагатай.

Харилцагчийн мэдээллийг нягтлах хугацаа



## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

- ХТМ үйл ажиллагаа явуулахад энэ зөвлөмжийн тайлбар болон Зөвлөмж 1-ийн тайлбарыг ашиглана.

**Зөвлөмж 1-ийн тайлбар:** мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн судалгааг үндэсний хэмжээнд хийж өндөр эрсдэлтэй салбарыг тогтоох, энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн байгууллагад ХТМ шалгуурыг өндөрсгөх, бага эрсдэлтэй салбарт ХТМ үйл ажиллагааг хялбаршуулах боломж олгох.

**Зөвлөмж 10-ын тайлбар:** Санхүүгийн байгууллага харилцагчийн эрсдэлийн түвшинг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд ХТМ үйл ажиллагааг өргөтгөх

Эрсдэлийг үнэлэх үзүүлэлт:

Харилцагчийн мэдээлэл

Улс/Газар зүйн байршил

Бүтээгдэхүүн үйлчилгээ

Бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх хэлбэр

Зөвлөмж 10



## Зөвлөмж 10, Харилцагчийг таньж мэдэх

- ХТМ үүргээ хэрэгжүүлэх боломжгүй бол:
  - Данс нээх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах
  - тогтоосон бизнесийн харилцааг зогсоох
  - Сэжигтэй гүйлгээний тайлангаар санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэх үүргийг хуульд тусгах.

ХТМ үүргээ хэрэгжүүлэх гэсэн оролдлого нь харилцагчийг сэжиглэж байгаа талаар өөрт нь сэжиг авхуулахаар байвал ХТМ оролдлогыг зогсоож шууд сэжигтэй гүйлгээний тайлан бөглөхийг зөвшөөрөх.

ХТМ үүргээ хэрэгжүүлэх боломжгүй бол



## Зөвлөмж 11-15

### Зөвлөмж 11 Мэдээллийн хадгалалт

1. Харилцагчийн хийж байгаа дотоод, гадаад бүх гүйлгээний баримт мэдээллийн 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалах,
2. ХТМ үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан бүх мэдээлэл
3. Хийгдсэн аливаа анализ дүгнэлт, бизнесийн харилцааны тухай мэдээлэл

Эдгээр мэдээлэл нь нотлох баримтын хэмжээнд ашиглах боломжтой, санхүүгийн харилцаанд орж байгаа талууд, өмчлөгчийг тогтоох боломжтой байх, эрх бүхий байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөх боломжтой байх.

Зөвлөмж 11



## Зөвлөмж 11-15

### □ Зөвлөмж 12 Улс төрийн нөлөө бүхий этгээд

1. Дотоодын

2. Гадаадын

3. Олон улсын байгууллагын

4. Гэр бүлийн гишүүд эсхүл ойрын харилцаатай этгээд

- Санхүүгийн байгууллага нь харилцагч эсхүл түүний цаана байгаа өмчлөгч нь улс төрийн нөлөө бүхий этгээд мөн эсэхийг тодорхойлох эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх үүрэгтэй.
- Улс төрийн нөлөө бүхий этгээд мөн бол бизнесийн харилцаа тогтоохын өмнө дээд түвшний удирдлагын зөвшөөрлийг авах
- Уг харилцагчийн хөрөнгө орлогын хэмжээ, эх үүсвэрийг тогтоох талаар боломжтой бүхий л арга хэмжээг авах
- Данс, гүйлгээнд байнгын хяналт тавих үүрэгтэй.

Зөвлөмж 12



## Зөвлөмж 11-15

### □ Зөвлөмж 13 Корреспондент банк

1. Харилцагч санхүүгийн байгууллагын МУТС-тэй холбоотой хэрэгт шалгагдаж байсан эсэх, зохицуулалтын байгууллагаас арга хэмжээ авч байсан эсэх, нэр хүндийн талаар олон нийтэд нээлттэй мэдээллийн эх үүсвэрээс судалгаа хийх,
2. МУТС-тэй тэмцэх хяналтын тогтолцоог нь үнэлэх
3. Харилцаа тогтоохын өмнө дээд түвшний удирдлагын зөвшөөрлийг авах,
4. Харилцагч банкууд харилцан бие биенийхээ МУТС-тэй тэмцэх үүрэг хариуцлагыг тодорхой ойлгож байх
5. Дансыг бусдад ашиглуулж байгаа эсэхийг мэдэх
6. ХТМ хуулиар хүлээсэн үүрэгтэй эсэхийг мэдэх
7. өөрийн харилцагчийн тухай мэдээллийг хүсэлт гаргасан тохиолдолд гаргаж өгөх эсэхийг мэдэх
8. Бодитоор оршдоггүй банктай харилцаа тогтоох хориотой. Харилцаж байгаа банк ч гэсэн энэ шаардлагад нийцсэн байх.

Зөвлөмж 13



## Зөвлөмж 11-15

### □ Зөвлөмж 14 Мөнгөн гуйвуулга

1. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий байгууллагад бүртгэлтэй эсхүл тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.
2. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчийн гадаад улс орон, болон дотоодод байгаа бүх агентууд бүртгэлд хамрагдсан байх шаардлагатай.
3. МУТС-тэй тэмцэх чиглэлээр эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалт хийгддэг байх
4. Зөвшөөрөл, бүртгэлгүйгээр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг этгээдийг илрүүлэх, арга хэмжээ авах шаардлагатай.
5. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч өөрийн дотоод МУТС тэмцэх бодлого журамтай байх бөгөөд бүх агентууд МУТСТ хууль болон дотоод бодлого журамдаа нийцүүлэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

Зөвлөмж 14



## Зөвлөмж 11-15

### □ Зөвлөмж 15 Шинэ технологи

Улс орнууд болон санхүүгийн байгууллагууд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдээрийн харилцагчид хүргэх арга хэлбэр гарах, шинэ технологи хэрэглээнд нэвтрүүлэхийн өмнө түүнээс үүдэн гарах МУТС эрсдэлийг үнэлэх үүрэгтэй. Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний өөрийнх эрсдэл, хуучин бүтээгдэхүүн үйлчилгээтэй хоршиж үүсэх эрсдэлийг судалж гарч болох эрсдэлийг бууруулах, хяналтанд авах арга хэмжээг авах үүрэгтэй.

Зөвлөмж 15





## Зөвлөмж 16

### □ Зөвлөмж 16 Данс хоорондын гүйлгээ

Санхүүгийн байгууллагууд **1000 USD/EUR** болон түүнээс дээш дүнтэй бүх төрлийн гадаад гүйлгээ хийх бүрдээ:

1. Гүйлгээ хийж буй этгээдийн дансны дугаар, эсхүл давтагдахгүй гүйлгээний дугаар /гүйлгээг тодруулж лавлах боломжтой байх/
2. Овог нэр
3. Гүйлгээ хийж буй этгээдийн иргэний үнэмлэх/паспортын дугаар, төрсөн огноо, газар, харилцагчийн дугаар
4. Хүлээн авагчийн овог нэр
5. Хүлээн авагчийн дансны дугаар

Эдгээр мэдээллийн үнэн бодит эсэхийг тогтоосон байна./verify/  
**1000 USD/EUR**-аас бага бол 3 дугаар шаардлага байхгүй. Мөн мэдээллийн бодит эсэхийг тогтоох шаардлага байхгүй.

Зөвлөмж 16



## Зөвлөмж 16

- ❑ Дотоодын данс хоорондын гүйлгээний хувьд хүлээн авагч шилжүүлэгч талын мэдээлэлд тавих шаардлага ижилхэн.
- ❑ Мэдээлэл нь гүйлгээнд оролцогч талуудыг тогтооход хангалттай хэмжээнд байх шаардлагатай бөгөөд, эрх бүхий байгууллага болон хүлээн авагч санхүүгийн байгууллагын хүсэлтээр ажлын 3 хоногт гаргаж өгөх үүрэгтэй. Хууль сахиулах байгууллаг гүйлгээнд оролцогч талуудын мэдээлэлд нэн даруй нэвтрэх эрхтэй байх шаардлагатай. /Зөвлөмж 11-д заасан мэдээлэл/
- ❑ Санхүүгийн байгууллага дээрх Зөвлөмж 16-д дурдсан шаардлагад нийцээгүй данс хоорондын гүйлгээг хийх нь хуулиар зөвшөөрөгдөөгүй байх шаардлагатай.
- ❑ Хүлээн авагч санхүүгийн байгууллага данс хоорондын гүйлгээнд шаардлагатай мэдээлэл бүрэн гүйцэт байгаа эсэхийг “real-time” эсхүл “post-event” хэлбэрийн аль боломжтойгоор нь хяналт тавьж байх үүрэгтэй.

Зөвлөмж 16



## Зөвлөмж 16

- ❑ **1000 USD/EUR** болон дээш дүнтэй гүйлгээнд хүлээн авагч санхүүгийн байгууллага хүлээн авагчийн мэдээллийг Зөвлөмж 11-ийн дагуу бүрдүүлнэ.
- ❑ Санхүүгийн байгууллага хүлээн авсан данс хоорондын гүйлгээг буцаах, биелүүлэх, түдгэлзүүлэх талаар баримтлах эрсдэлд суурилсан бодлого журамтай байх үүрэгтэй.
- ❑ Уг журамд түдгэлзүүлсэн болон буцаасан тохиолдолд авах арга хэмжээг мөн тусгасан байна.
- ❑ Данс хоорондын гүйлгээнд шилжүүлэгч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагуудын голд дамжуулах үүрэгтэй оролцож байгаа 3-дагч санхүүгийн байгууллага байгаа тохиолдолд хүлээн авагч, шилжүүлэгчийн мэдээлэл бүрэн бичигдсэн эсэхэд хяналт тавих үүрэг хүлээнэ.
- ❑ Дамжин өнгөрч байгаа гүйлгээний талаарх мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалах үүрэгтэй.

Зөвлөмж 16



## Зөвлөмж 16

- ❑ Дамжуулагч санхүүгийн байгуулага дамжин өнгөрөх данс хоорондын гүйлгээг буцаах, биелүүлэх, түдгэлзүүлэх талаар баримтлах эрсдэлд суурилсан бодлого журамтай байх үүрэгтэй.
- ❑ Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч этгээд нь Зөвлөмж 16-д нийцүүлэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.
- ❑ Данс хоорондын гүйлгээг сэжигтэй эсэхийг тогтоохын тулд хүлээн авагч болон шилжүүлэгч талын аль аль нь нөгөө талаасаа мэдээлэл хүсэж болно. Сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авагч болон шилжүүлэгч, дамжин өнгөрч байгаа аль ч санхүүгийн байгууллага өөрсдийн СМА-нд явуулж болно.

Зөвлөмж 16



# Асуулт хариулт



МОНГОЛЫН ХАМГААГАХ АЖ АХУЙ



For more information:

- ❑ FATF Public website: [www.fatf-gafi.org](http://www.fatf-gafi.org)
- ❑ APG Public website: [www.apgml.org](http://www.apgml.org)

**АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА**

МОНГОЛ УЛСЫН  
ХӨГЖИЛЙН БАНК